



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 4/110

Мандалговь

Г Түлш, шатахууны чанарт
шинжилгээ хийлгэх тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлын 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 04 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Иргэдээс ирүүлсэн санал, гомдлын дагуу аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа шатахуун түгээх станц/ШТС/-уудын түлш, шатахууны чанарт итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэх ажлыг зохион байгуулсугай.

Хоёр. Чанарын шинжилгээг баталгаажуулж, үйл ажиллагааны стандартад хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан, иргэдийн өргөдөл, гомдлыг барагдуулж, олон нийтэд танилцуулахыг Мэргэжлийн хяналтын газар/Ш.Төрбат/, Сайнцагаан сумын Засаг дарга/Р.Мөнхтогтох/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтийг ханган, түлш, шатахууны чанарын шинжилгээний төлбөрийг хариуцан гаргаж, хамтран ажиллахыг ШТС-ын захирал, удирдлагуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200341